



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 67

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 2,136,789,93 /хоёр сая нэг зуун гучин зургаан мянга долоон зуун наян есөн төгрөг өрэн гурван мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 819,102.86 /найман зуун арван есөн мянга нэг зуун хоёр төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан 2 нэр төрлийн хөрөнгийг “Боржигон мандал” өрхийн эрүүл мэндийн төвд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Эрүүл мэндийн газрын дарга (Б.Алтантөгс), “Боржигон мандал” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Ч.Сумъяа) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
67 дугаар тогтоолын хавсралт

Эрүүл мэндийн газраас "Боржигон мандал" ОЭМТ-д
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хурумтлагдсан элэгдэл	Үлдээгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Компьютер	2016.09	Ш	1	1,736,397,03	665,611.96	1,070,767.07	"Боржигон мандал" ОЭМТ
2	Тог баригч	2016.09	Ш	1	400,410,90	153,490.90	246,920.00	"Боржигон мандал" ОЭМТ
Нийт дун								
				2	2,136,789,93 /хоёр сая нэг зуун гучин зургаан мянга долоон зуун наян есөн төгрөг ерэн гурван мөнгө/ төгрөг	819,102.86 /найман зуун арван есөн мянга нэг зуун хоёр төгрөг наян зургаан мөнгө/ төгрөг	1,317,687.07 /нэг сая гурван зуун арван долоон мянга зургаан зуун наян долоон төгрөг долоон мөнгө/ төгрөг	